



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/118

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 19 дугаар зөвлөмжийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Цагдаагийн газрын барилга /Өвөрхангай аймгийн Арвайхээр сум/ барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 1,698,101,000 (нэг тэрбум зургаан зуун ерэн найман сая нэг зуун нэг мянга) Бат-Угсралт констракшн ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Цагдаагийн ерөнхий газартай гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100268